



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд нийлүүлсэн нийт 378,901,152.24 (гурван зуун далан найман сая есөн зуун нэг мянга нэг зуун тавин хоёр төгрөг хорин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн
176 дугаар тогтоолын хавсралт

"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

/Монгол банкны 2018.11.29-ны өдрийн ханш 1\$=2666.14/

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /ам.доллар/	Балансын үнэ /ам.доллар/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/
1	Суурин компьютер	ш	31	901.00	27,931.00	2,402,192.14	74,467,956.34
2	Зөөврийн компьютер	ш	5	1,235.00	6,175.00	3,292,682.90	16,463,414.50
3	Принтер А4	ш	10	466.00	4,660.00	1,242,421.24	12,424,212.40
4	Өнгөт принтер А4	ш	1	488.00	488.00	1,301,076.32	1,301,076.32
5	Принтер А3	ш	3	1,685.00	5,055.00	4,492,445.90	13,477,337.70
6	Сервер компьютер	ш	1	4,100.00	4,100.00	10,931,174.00	10,931,174.00
7	Сервер компьютер	ш	5	2,693.00	13,465.00	7,179,915.02	35,899,575.10
8	Серверийн дагалдах төхөөрөмж	ш	5	1,014.00	5,070.00	2,703,465.96	13,517,329.80
9	Галт ханын төхөөрөмж /Firewall/	ш	4	3,390.00	13,560.00	9,038,214.60	36,152,858.40
10	Галт ханын төхөөрөмж /Firewall/	ш	1	7,850.00	7,850.00	20,929,199.00	20,929,199.00
11	Сүлжээний свич	ш	5	427.00	2,135.00	1,138,441.78	5,692,208.90
12	Сүлжээний свич	ш	1	953.00	953.00	2,540,831.42	2,540,831.42
13	Patch panel	ш	1	137.00	137.00	365,261.18	365,261.18
14	Patch panel	ш	5	91.00	455.00	242,618.74	1,213,093.70
15	Тог баригч	ш	5	8,244.00	41,220.00	21,979,658.16	109,898,290.80

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /ам.доллар/	Балансын үнэ /ам.доллар/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/
16	Фото камер	Ш	1	3,300.00	3,300.00	8,798,262.00	8,798,262.00
17	Киоск	Ш	6	927.00	5,562.00	2,471,511.78	14,829,070.68
	Нийт дүн		90	37,901.00 \$	142,116.00 \$	101,049,372.14 (нэг зуун нэг сая дөчин есөн мянга гурван зуун далан хоёр төгрөг арван дөрвөн мөнгө)	378,901,152.24 (гурван зуун далан найман сая есөн зуун нэг мянга нэг зуун тавин хоёр төгрөг хорин дөрвөн мөнгө)